



Бэлгээ хэргийн тугийн хэргийн
11 сны 11 дугаар сарын 17
№43 /712/

МОНГОЛ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1682

Монгол Улсын
хууль

1704

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1711

Жолоочийн даатгалын тухай

Ялтан шилжүүлэх тухай гэрээ
соёрхон батлах тухай

Түүх, соёлын дурсгалд
хамааруулж, хамгаалалтын бүс
тогтоох тухай

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

402.	Жолоочийн даатгалын тухай	1682
403.	Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1698
404.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1700
405.	Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1701
406.	Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай	1701
407.	Үрийн гаривчлангийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1702
408.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1702
409.	Нийгэмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1703
410.	Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1703
411.	Өмгөөллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1703
412.	Ялтан шилжүүлэх тухай гэрээ соёрхон батлах тухай	1704

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

413.	Жолоочийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 43	1704
414.	"Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 46	1705

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

415.	Журалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 264	1706
416.	Түүх, соёлын дурсгалд хамааруулж, хамгаалалтын бүс тогтоох тухай	Дугаар 271	1711

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомж

2.1.Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид "жолоочийн даатгал" гэх/-ын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай³, Даатгалын тухай⁴, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай⁵, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай⁶, Автотээврийн тухай хууль⁷, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

¹ Монгол Улсын Үндсэн хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

³ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2005 оны 46 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Даатгалын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2004 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2004 оны 20 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Автотээврийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."жолооч" гэж автотээврийн хэрэгсэл болон мотоциклийг жолоодож яваа хүнийг;

3.1.2."автотээврийн хэрэгсэл" гэж Автотээврийн тухай хуулийн 3.1.1-д заасныг;

3.1.3."даатгагч" гэж даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулж, уг гэрээнд заасан нөхцөл, хэмжээгээр хохирогчид нөхөн төлбөр олгох үүрэг хүлээсэн, жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг;

3.1.4."даатгуулагч" гэж даатгагчтай гэрээ байгуулж замын хөдөлгөөнд оролцох үедээ бусад этгээдийн өмнө хүлээх хариуцлагаа даатгуулсан этгээдийг;

3.1.5."даатгуулагчийн итгэлийн түүх" гэж даатгагчаас даатгуулагчийн талаар хөтөлж байгаа мэдээллийг;

3.1.6."жолоочийн даатгалын нөхөн төлбөр" /цаашид "нөхөн төлбөр" гэх/ гэж жолоочийн даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгалын гэрээний дагуу даатгагчаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгө болон даатгалын гэрээгээр даатгалын нөхөн төлбөр олгох боломжгүй бол жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгох мөнгөн хөрөнгийг;

3.1.7."жолоочийн даатгалын сан" гэж жолоочийн даатгалд хамрагдаагүй, эсхүл гэрээний хугацаа дууссан түүнчлэн даатгалын тохиолдол гаргасан жолооч зугтаасан болон даатгагч нь дамлуурсан зэрэг тохиолдолд жолоочоос бусад этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хэд хэдэн даатгагч хамтарч энэ хуульд заасны дагуу байгуулсан санг;

3.1.8."жолоочийн даатгалын сангийн шуурхай алба" /цаашид "шуурхай алба" гэх/ гэж даатгагч, даатгуулагч, жолооч, хохирогч иргэнээс жолоочийн даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авч, шуурхай, үнэн зөв тодорхойлох боломжийг даатгагч, даатгуулагч, хохирогчид бүрдүүлэх чиглэлээр туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг албыг;

3.1.9."жолоочийн даатгалын тохиолдол" /цаашид

"даатгалын тохиолдол" гэх" гэж жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж, хариуцлага хүлээх тохиолдлыг;

3.1.10."хохирогч" гэж даатгалын тохиолдлын улмаас эрүүл мэнд, эд хөрөнгөд нь хохирол учирсан этгээд, эсхүл даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас хохирсон тохиолдолд гэм хор учруулсны төлбөрийг шаардах эрх бүхий этгээдийг.

4 дүгээр зүйл. Даатгалын зарчим

4.1. Жолоочийн даатгал нь дараах зарчимд үндэслэнэ:

4.1.1. тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал хамрагдах;

4.1.2. хохирогчид нөхөн төлбөр олгох;

4.1.3. жолоочийн даатгалд даатгуулаагүй жолооч замын хөдөлгөөнд оролцохгүй байх;

4.1.4. зам, тээврийн ослын улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах санхүүгийн эх үүсвэр бий болгох.

5 дугаар зүйл. Даатгуулах этгээд

5.1. Тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал даатгуулна.

5.2. Тээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн даатгалд даатгуулаагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг ашиглан замын хөдөлгөөнд оролцох, тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах, улсын бүртгэлд бүртгүүлэхийг хориглоно.

5.3. Автотээврийн тухай хуулийн 3.1.15-д заасан тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч болон "С", "D" ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч эсхээс үл хамааран жолоочийн даатгалд заавал даатгуулна.

6 дугаар зүйл. Даатгалд үл хамрагдах нөхцөл

6.1. Монгол Улс гишүүнээр нь элсэн орсон олон улсын албан журмын даатгалын холбооны гишүүн орны даатгалын эрх бүхий байгууллагад даатгуулсан этгээд энэ хуулиар тогтоосон даатгалд хамрагдахгүй байж болно.



6.2.Замын хөдөлгөөнд оролцдоггүй байлдааны тусгай зориулалттай тээврийн хэрэгсэлд энэ хууль хамаарахгүй.

6.3.Хохирогч нь энэ хуулиар тогтоосон хэмжээнээс давсан хохирлыг жолооч болон буруутай этгээдээс нэхэмжилсэн бол уг давсан хэсэгт энэ хууль үйлчлэхгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ГЭРЭЭ

7 дугаар зүйл. Даатгалын гэрээ, түүний хугацаа

7.1.Жолооч нь замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулж болзошгүй хохирлыг нөхөн төлөх зорилгоор энэ хуульд заасан нөхцөлийн дагуу даатгагчтай даатгалын гэрээ байгуулна.

7.2.Даатгуулагч батлагдсан маягтын дагуу даатгагчид мэдүүлэг бөглөж өгнө.

7.3.Даатгалын гэрээг энэ хуулийн 7.4-т заасан стандарт, загварын дагуу бичгээр байгуулах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

7.4.Даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загварыг Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.

7.5.Даатгуулагч нь даатгагчаа сайн дураараа чөлөөтэй сонгох эрхтэй.

7.6.Даатгалын гэрээ нэг жил хүртэл хугацаанд хүчинтэй байх бөгөөд даатгуулагчаас даатгалын хураамж төлснөөр хүчин төгөлдөр болно.

7.7.Даатгагч нь даатгалын гэрээний хугацаанд бий болсон уг гэрээтэй холбоотой бүхий л мэдээллийг даатгуулагчид үнэ төлбөргүй гаргаж өгөх үүрэгтэй.

8 дугаар зүйл. Даатгалын баталгаа

8.1.Даатгалын гэрээ байгуулсан даруйд даатгагч нь гэрээ байгуулсныг гэрчлэх даатгалын баталгааг даатгуулагчид өгнө.

8.2.Жолооч нь даатгалын баталгааг автотээврийн хэрэгсэлд байнга байршуулж эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд шалгуулна.



8.3. Даатгалын баталгааны загвар, хэрэглэх журмыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖ

9 дүгээр зүйл. Даатгалын үнэлгээ

9.1. Жолоочийн даатгалын үнэлгээний хэмжээ буюу даатгалын тохиолдол бүрд 1 удаа олгох нөхөн төлбөр нь дараах хэмжээтэй байна:

9.1.1. энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.5-д заасан тээврийн хэрэгслийн хувьд таван сая төгрөг хүртэл;

9.1.2. энэ хуулийн 10.1.3, 10.1.4-т заасан тээврийн хэрэгслийн хувьд арван сая төгрөг хүртэл.

9.2. Даатгалын үнэлгээ нь энэ хуулийн 9.1-д заасан үнэлгээнээс өндөр байхаар даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож болох бөгөөд энэ тохиолдолд даатгалын хураамжийн хэмжээг даатгалын гэрээнд заасны дагуу энэ хуульд зааснаас өөрөөр тогтоож болно.

10 дугаар зүйл. Даатгалын суурь хураамж

10.1. Энэ хуулийн 5.1-д заасан даатгуулагч нь дараах даатгалын суурь хураамжийг төлнө:

10.1.1. "А" ангиллын тээврийн хэрэгсэлд 12 500 төгрөг;

10.1.2. "В" ангиллын тээврийн хэрэгсэлд 33 000 төгрөг;

10.1.3. "С" ангиллын тээврийн хэрэгсэлд 42 500 төгрөг;

10.1.4. "D" ангиллын тээврийн хэрэгсэлд 53 000 төгрөг;

10.1.5. "Механизм" ангиллын тээврийн хэрэгсэлд 12 500 төгрөг.

10.2. Энэ хуулийн 5.3-т заасан даатгуулагч 33 000 төгрөгийн даатгалын суурь хураамжийг төлнө.

11 дүгээр зүйл. Даатгалын хураамж

11.1. Даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо даатгалын суурь хураамжийн хэмжээг дараах итгэлцүүрээр нэмэгдүүлэх буюу хоригдуулан тооцно:

11.1.1.тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршил;

11.1.2.өмнөх гэрээний хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээ;

11.1.3.даатгуулагчийн нас, автотээврийн хэрэгсэл жолоодох туршлага;

11.1.4.даатгалын гэрээний хугацаа;

11.1.5.даатгалын хураамжийн хэмжээг журамд зааснаас доогуур тогтоосон, эсхүл нөхөн төлбөрийг нэмэгдүүлэхэд нөлөөлөхүйц худал мэдүүлэг санаатай өгсөн эсэх;

11.1.6.тээврийн хэрэгслийг ашиглах жолоочийн тоо;

11.1.7.тээврийн хэрэгслийн давц, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадал;

11.1.8.тээврийн хэрэгслийн зориулалт;

11.1.9.чиргүүлтэй эсэх.

11.2.Даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ, НӨХӨН ТӨЛБӨР

12 дугаар зүйл. Даатгалын тохиолдолд үл хамаарах хохирол

12.1. Дараах хохирол даатгалын тохиолдолд үл хамаарна:

12.1.1. сэтгэл санааны хохирол;

12.1.2. хүрээлэн байгаа орчныг бохирдуулснаас үүссэн хохирол;

12.1.3. даатгуулагчийн автотээврийн хэрэгсэл, ачаанд учирсан хохирол;

12.1.4. энэ хууль болон даатгалын гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан хохирол.

12.2. Энэ хуулийн 12.1-д заасан хохирлын нөхөн төлбөрийг Монгол



Улсын холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэртэнэ.

13 дугаар зүйл. Жолоочийн хүлээх үүрэг

13.1. Даатгалын тохиолдол гаргасан бол даатгуулагч дараах үүрэгтэй:

13.1.1. жолоочийн даатгалд даатгуулсан тухайгаа хохирогчид мэдэгдэх;

13.1.2. даатгалын тохиолдол гарсан талаар даатгагч, цагдаагийн байгууллагад мэдэгдэх, даатгалын баталгааг шалгуулах;

13.1.3. даатгалын тохиолдол болон нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгагчийн болон эрх бүхий этгээдийн шаардсан хугацаанд гаргаж өгөх;

13.1.4. даатгагч нь дампуурсан бол шуурхай албанд болон шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх.

13.2. Даатгалын тохиолдол гаргасан даатгуулаагүй жолооч дараах үүрэг хүлээнэ:

13.2.1. жолоочийн даатгалд даатгуулаагүй тухайгаа хохирогчид мэдэгдэх;

13.2.2. даатгалын тохиолдлын талаар шуурхай алба, цагдаагийн байгууллагад мэдэгдэх.

13.3. Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан этгээд нь даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягтыг даатгалын тохиолдол гарсан даруйд бөглөж, гарын үсэг зурна.

13.4. Даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлыг тухайн даатгалын тохиолдол гарсан даруйд нөхөн төлөхөөр жолооч хохирогчтой тохиролцсон бол даатгагчид энэ тухайгаа мэдэгдэх бөгөөд даатгагчаас эргэн төлүүлэхээр даатгагчийн зааврын дагуу хохирлыг жолооч барагдуулж болно.

13.5. Даатгуулагч энэ хуулийн 13.1, 13.4-т заасан үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг даатгагч, жолоочийн даатгалын сан хариуцахгүй бөгөөд хохирлыг даатгуулагч өөрөө хариуцна.



13.6. Даатгуулаагүй жолооч энэ хуулийн 13.2-т заасан үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг даатгагч, жолоочийн даатгалын сан хариуцахгүй бөгөөд хохирлыг жолооч өөрөө хариуцна.

14 дүгээр зүйл. Хохирогчийн хүлээх үүрэг

14.1. Даатгалын тохиолдол гаргасан жолооч зугтаасан бол хохирогч шуурхай алба, цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

14.2. Хохирогч нь амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөдөө учирсан хохирлыг нотлох бүх мэдээллийг даатгагч, шуурхай алба, даатгалын хохирол үнэлэгчид гаргаж өгөх үүрэгтэй.

15 дугаар зүйл. Даатгагч, жолоочийн даатгалын сангийн эрх, үүрэг

15.1. Даатгагч, жолоочийн даатгалын сан нь нөхөн төлбөр буюу хохирлын хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгуулагч, хохирогчоос шаардах эрхтэй.

15.2. Даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авсан даруйд даатгагч, шуурхай алба нь даатгалын тохиолдол болсон газарт төлөөлөгчөө шуурхай илгээх үүрэгтэй.

15.3. Даатгагч нь энэ хуулийн 19.2-т зааснаас бусад тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ, даатгуулагчийн гэм бурууг тогтоосны дараа гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүргээс даатгалын гэрээнд заасан хэмжээгээр даатгуулагчийг чөлөөлнө.

16 дугаар зүйл. Даатгалын тохиолдлыг шалгах

16.1. Даатгагч, жолоочийн даатгалын сангийн төлөөлөгч нь хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, даатгуулагч өргөдөл гаргаснаас хойш 3 хоногийн дотор даатгалын тохиолдлыг шалгаж, даатгалын хохирол үнэлэгчийг томилох үүрэгтэй.

16.2. Даатгалын тохиолдол болсон газар нутгийн байршлыг харгалзан даатгагч, жолоочийн даатгалын сангийн төлөөлөгч нь энэ хуулийн 16.1-д заасан хугацааг хохирогч, даатгуулагчийн зөвшөөрлийн дагуу 10 хүртэл хоногоор сунгаж болно.

16.3. Хуульд заасан эрх бүхий этгээд, эсхүл даатгалын хохирол үнэлэгч нь даатгалын тохиолдлыг шалгах, хохирлын хэмжээг тогтоох



зорилгоор тухайн автотээврийн хэрэгсэлд техникийн үзлэг хийж болно.

16.4.Даатгагч, жолоочийн даатгалын сангийн төлөөлөгч нь энэ хуулийн 16.1-д заасан хугацаанд даатгалын тохиолдлыг шалгаагүй, эсхүл даатгалын хохирол үнэлэгчийг томилоогүй бол даатгуулагч, жолооч, хохирогч нь Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 3.2.4-т заасан даатгалын хохирол үнэлэгч этгээдэд хандах эрхтэй.

16.5.Даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэхтэй холбогдон гарах зардлыг даатгагч, жолоочийн даатгалын сан хариуцна.

16.6.Даатгалын тохиолдлыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6-д заасан даатгалын тохиолдлын тодорхойлолтыг үндэслэн тогтооно.

17 дугаар зүйл.Хохирлын хэмжээг тодорхойлох

17.1.Хуульд өөрөөр заагаагүй бол даатгагч, даатгалын хохирол үнэлэгч болон хуульд заасан эрх бүхий этгээд нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээг дараах журмын дагуу тодорхойлно:

17.1.1.хохирогч нас барсан бол Иргэний хуулийн 508 дугаар зүйлд заасны дагуу;

17.1.2.хохирогчийн эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээний талаар хохирогч, даатгуулагч, даатгагч талууд санал нэгдсэн бол тэдгээрийн харилцан тохиролцсон хэмжээгээр;

17.1.3.хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирлын хэмжээний талаар хохирогч, даатгуулагч, даатгагч талуудын санал зөрсөн бол Иргэний хуулийн 505 дугаар зүйлд заасны дагуу;

17.1.4.хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээний талаар хохирогч, даатгуулагч, даатгагч талуудын санал зөрсөн бол Иргэний хуулийн 510 дугаар зүйлд заасны дагуу.

18 дугаар зүйл.Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох

18.1.Дараах үндэслэлийн аль нэг нь байвал жолоочийн даатгалын сан хохирогчийн өргөдлийг үндэслэн түүнд нөхөн төлбөр олгоно:

18.1.1.даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан;



18.1.2.даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан;

18.1.3.бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус;

18.1.4.даатгагч дампуурсан;

18.1.5.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

19 дүгээр зүйл.Нөхөн төлбөр олгох

19.1.Даатгагч, жолоочийн даатгалын сан нь хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээг хуульд заасан эрх бүхий этгээд, эсхүл даатгалын хохирол үнэлэгчийн дүгнэлт, тодорхойлолт, энэ хуулийн 17 дугаар зүйлд заасныг үндэслэн тогтооно.

19.2.Хохирогчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол даатгуулагчийн гэм буруутай нь тогтоогдсон эсэхээс үл хамааран даатгагч, жолоочийн даатгалын сан нь энэ хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосноос хойш ажлын 10 өдрийн дотор нөхөн төлбөрийг хохирогчид олгоно.

19.3.Хохирогчийн эд хөрөнгөд хохирол учирсан бол даатгуулагчийн гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд энэ хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан журмын дагуу нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосноос хойш 1 сарын дотор нөхөн төлбөрийг хохирогчид олгоно.

19.4.Даатгагч, жолоочийн даатгалын сан нь хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулахдаа хохирогчтой тохиролцсоны дагуу даатгалын үнэлгээнд багтаан эд хөрөнгийг засуулахаар тохиролцож болно.

19.5.Нөхөн төлбөрийн хэмжээг бүрэн тогтоох хүртэл хохирогчийн хүсэлтийн дагуу нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгож болно.

19.6.Нөхөн төлбөрийн хэмжээг бүрэн тогтоохоос өмнө хэд хэдэн хохирогчийн хүсэлтээр нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгохоор бол эхний удаад хохирогч бүрд ижил хэмжээгээр, хохирлын хэмжээ бүрэн тогтоогдсоны дараа хувь тэнцүүлэн олгоно.

19.7.Хэд хэдэн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан хэмжээнээс хэтэрсэн бол хохирогч бүрд олгох нөхөн төлбөрийг хувь тэнцүүлэн олгоно.

19.8.Даатгагч, жолоочийн даатгалын сан нь хохирогчид олгосон



нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг сар бүр цагдаагийн байгууллагад ирүүлэх ба мэдээлэл ирүүлэх, түүнийг хэрэглэх журмыг Санхүүгийн зохицуулах хороо, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

19.9.Хохирогчид олгох нөхөн төлбөрийн 80 хүртэл хувийг хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохиролд, 20 хүртэл хувийг хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохиролд олгоно.

19.10.Энэ хуулийн 5.1-д заасан даатгуулагчийн тээврийн хэрэгслийг мөн хуулийн 5.3-т заасан даатгуулагч жолоодож байх үед үүссэн даатгалын тохиолдол бүрд нөхөн төлбөрийг даатгуулагч тус бүрийн төлсөн даатгалын хураамжийн харьцаагаар даатгагч тус бүр хариуцан төлнө.

20 дугаар зүйл.Нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх үндэслэл

20.1.Даатгагч нь дараах тохиолдолд хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхтэй:

20.1.1.хохирогчид хохирол учирсан нь даатгуулагчийн гэм буруутай холбогдолгүй болох нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн буруутай этгээдээс;

20.1.2.даатгалын тохиолдол гарсан талаар энэ хуулийн 13.1, 13.2-т заасан этгээдэд мэдэгдээгүй бол даатгуулагч, жолоочоос;

20.1.3.даатгуулагч нь даатгалын тохиолдол болсон газраас зугтаасан бол тухайн даатгуулагчаас;

20.1.4.даатгуулагч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ даатгалын тохиолдол гаргасан бол даатгуулагчаас;

20.1.5.хуульд заасан бусад тохиолдолд буруутай этгээдээс.

20.2. Жолоочийн даатгалын сан нь дараах тохиолдолд хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхтэй:

20.2.1.хохирогчид хохирол учирсан нь жолоочийн гэм буруутай холбогдолгүй болох нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн буруутай этгээдээс;

20.2.2.даатгалгүй жолоочийн гэм буруугаас шалтгаалан хохирогчид хохирол учирсан гэдэг нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн жолоочоос;

20.2.3.даатгалын тохиолдол гаргаад зугтаасан жолоочийн учруулсан хохирлын хувьд тухайн жолоочоос;

20.2.4.даатгагч нь дамлуурсан бол хуулийн дагуу эрх залгамжлан авсан этгээдээс;

20.2.5.хуульд заасан бусад үндэслэл.

ТАВДУГААР БҮЛЭГ ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ

21 дүгээр зүйл.Жолоочийн даатгалын сан

21.1.Жолоочийн даатгалын сан нь Даатгалын тухай хуулийн 12¹.3.3.-т заасан албан журмын даатгалын сангийн бүрдэл хэсэг бөгөөд албан журмын даатгалын бусад хэлбэрийн сангаас тусдаа бүртгэлтэй, бие даасан данстай байна.

21.2.Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлд заасан Албан журмын даатгагчдын холбоо нь Жолоочийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг жил бүр гаргах бөгөөд уг сангийн үйл ажиллагаа, тайланд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.

21.3.Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

22 дугаар зүйл.Жолоочийн даатгалын сангийн бүрдүүлэлт

22.1.Жолоочийн даатгалын сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

22.1.1.жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагч бүрээс төвлөрүүлэх хөрөнгө;

22.1.2.энэ хуулийн 28.1-д заасан орлогын 50 хувь;

22.1.3.энэ хуулийн 20.2-т заасны дагуу буцаан нэхэмжилсэн нөхөн төлбөр;

22.1.4.автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь;

22.1.5.энэ хуулийн 24.6-д заасан мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого;

22.1.6.зээл, тусламж, хандивын орлого.

22.2.Энэ хуулийн 22.1.1-д заасны дагуу төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран жил бүр тогтооно.

22.3.Энэ хуулийн 22.1.2, 22.1.4-т заасан эх үүсвэрийг Жолоочийн даатгалын сангийн дансанд шилжүүлэх журмыг санхүү, төсвийн болон авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

22.4.Жолоочийн даатгалын сангийн хөрөнгө үндсэн зорилгоо хэрэгжүүлэхэд хүрэлцэхгүй болсон тохиолдолд Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн шийдвэрээр тус холбооны гишүүнээс хөрөнгө татан төвлөрүүлж болно.

23 дугаар зүйл.Жолоочийн даатгалын сангийн зарцуулалт

23.1.Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулна:

23.1.1.энэ хуулийн 18.1-д заасан нөхөн төлбөр олгох;

23.1.2.энэ хуулийн 24.1-д заасан жолоочийн даатгалын мэдээллийн сан хөтлөх;

23.1.3.шуурхай алба, сангийн үйл ажиллагааг санхүүжүүлэх;

23.1.4.зам, тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг санхүүжүүлэх.

23.2. Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг энэ хуулийн 23.1-д зааснаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

23.3.Энэ хуулийн 23.1.4-т заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд жолоочийн даатгалын сангаас зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээг Албан журмын даатгагчдын холбоо тогтооно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙН САН, ШУУРХАЙ АЛБА

24 дүгээр зүйл.Жолоочийн даатгалын мэдээллийн сан

24.1.Жолоочийн даатгалын мэдээллийн сан /цаашид "мэдээллийн



сан" гэх/ нь Даатгалын тухай хуулийн 12'3.1-д заасан албан журмын даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн бүрдэл хэсэг байх бөгөөд албан журмын даатгалын бусад хэлбэрийн мэдээллийн сангаас тусдаа бүртгэлтэй, бие даасан мэдээллийн сан байна.

24.2.Мэдээллийн санд даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, хохирогчид олгосон нөхөн төлбөр, даатгагч, даатгуулагч, хохирогчийн болон жолоочийн даатгалтай холбоотой бусад мэдээллийг оруулна.

24.3.Мэдээллийн сангийн мэдээлэл нь нээлттэй, бүх нийтэд хүртээлтэй байна.

24.4.Даатгалын тухай хуулийн 12' дүгээр зүйлд заасан Албан журмын даатгагчдын холбооны гишүүн, даатгагч, даатгуулагч өөртэй нь холбоотой мэдээллийг, түүнчлэн жолоочийн даатгалтай холбоотой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж байгаа төрийн байгууллага, албан тушаалтан мэдээллийн сангийн мэдээллийг үнэ төлбөргүй ашиглах эрхтэй.

24.5.Энэ хуулийн 24.4-т зааснаас бусад тохиолдолд мэдээллийн сангийн мэдээллийг төлбөртэй ашиглуулна.

24.6.Мэдээллийн сангийн мэдээллийг ашиглуулах журам, үйлчилгээний хөлсний хэмжээг Албан журмын даатгагчдын холбоо тогтоох ба орлогыг нь мэдээллийн сангийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.

25 дугаар зүйл.Шуурхай алба

25.1.Шуурхай алба нь Даатгалын тухай хуулийн 12'3.2-т заасан шуурхай албаны бүрдэл хэсэг бөгөөд албан журмын даатгалын бусад хэлбэрийн шуурхай албаас тусдаа байж болно.

25.2.Шуурхай алба нь жолоочоос шаптгаалан гарсан зам тээврийн ослын талаарх мэдээллийг даатгуулагч, даатгагч, жолооч, хохирогч, иргэнээс хүлээн авч, даатгалын тохиолдлын улмаас хохирогчид олгох нөхөн төлбөрийг шуурхай, үнэн зөв тодорхойлох боломжийг даатгагч, даатгуулагч, жолооч, хохирогчид бүрдүүлэн ажиллана.

25.3.Шуурхай албаны ажиллах журам, бүтэц, бүрэлдэхүүнийг Албан журмын даатгагчдын холбооны саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо батална.



ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД

26 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагаанд тавих хяналт

26.1. Санхүүгийн зохицуулах хороо нь жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчдын үйл ажиллагааны нэгдсэн уялдааг хангаж, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавина.

26.2. Даатгалын тохиолдол байнга гаргадаг гэсэн үндэслэлээр даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолоочийг даатгагчид хуваарилах журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

26.3. Энэ хуулийн 5.1-5.3 дахь хэсгийн заалтын хэрэгжилтэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын алба болон автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус хяналт тавина.

26.4. Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийг хилийн бүсэд жолоочийн даатгалд хамруулах журмыг хил хамгаалалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална.

27 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх журам

27.1. Жолоочийн даатгалтай холбогдон гарсан маргааныг Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

28 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1. Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан даатгалын хяналтын улсын байцаагч хянан шалгагч болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын албаны улсын байцаагч уг буруутай этгээдэд дараах захиргааны хариуцлага ногдуулна:

28.1.1. энэ хуулийн 5.1-5.3, 8.2-т заасныг зөрчсөн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, жолоочийн даатгалд даатгуулах хүртэл тээврийн хэрэгслийг тусгай хашаа /талбай/-д байлгаж, зардлыг буруутай этгээдээр төлүүлэх;

28.1.2. даатгалын тохиолдол болон нөхөн төлбөрийн



хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгагчийн шаардсан хугацаанд гаргаж өгөөгүй даатгуулагчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

28.1.3.энэ хуулийн 16.1-д заасан үүргээ биелүүлээгүй даатгагч болон жолоочийн даатгалын санг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

28.1.4.жолоочийн даатгалын сангийн хөрөнгийг энэ хуулийн 23.1-д зааснаас бусад зориулалтаар ашигласан этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

28.1.5.жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийг зөрчсөн буюу биелүүлээгүй, тээврийн хэрэгслийн өмчлөгчийн тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулсан, улсын бүртгэлд бүртгэсэн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

28.1.6.энэ хуулийн 15, 16, 17, 19 дүгээр зүйлд заасан нөхцөл, журам, хугацаанд нийцүүлэн нөхөн төлбөрийг олгоогүй, эсхүл тодорхой үндэслэлийг заан татгалзах хариуг хохирогчид өгөөгүй даатгагч болон жолоочийн даатгалын санг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

28.1.7.зөвшөөрөлгүйгээр жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

28.1.8.Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авалгүйгээр даатгалын гэрээг шилжүүлсэн буюу үйл ажиллагаагаа нэгтгэсэн даатгагчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

28.1.9.энэ хуулийн 22.1.1-д заасны дагуу жолоочийн даатгалын санд хөрөнгө төвлөрүүлээгүй даатгагчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

28.1.10.хууль тогтоомжид заасан бусад.

29 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

29.2.Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгохтой холбоотой энэ хуулийн 18 дугаар зүйлийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

29.3.Энэ хуулийн 28.1.1 дэх заалтыг 2012 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

ДДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Даатгалын тухай хуульд дор дурдсан агуулгатай 12¹ дүгээр зүйл нэмсүгэй:

12¹ дүгээр зүйл.Даатгагчдын нэгдсэн холбоо

12¹.1.Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Албан журмын даатгагчдын холбоо /цаашид "Холбоо" гэх/-нд гишүүн болох үүрэгтэй.

12¹.2.Холбоонд албан журмын даатгагч бүр нэгдэх бөгөөд уг холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд даатгагч, даатгуулагч, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг оролцуулах ба удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороо батална.

12¹.3.Холбоо нь дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх алба, сантай байна:

12¹.3.1.албан журмын даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий даатгалын мэдээллийн нэгдсэн сан;



12¹.3.2. даатгагч, даатгуулагч, хохирогч, иргэнээс даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүтээн авч, даатгалын тохиолдлыг шуурхай, үнэн зөв тодорхойлох боломжийг даатгагч, даатгуулагч, хохирогчид бүрдүүлэх чиг үүрэг бүхий шуурхай алба;

12¹.3.3. албан журмын даатгалын сан.

12¹.4. Энэ хуулийн 12¹.3.3-т заасан даатгалын санг бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг албан журмын даатгалын хэлбэрийг тогтоосон хуулиар зохицуулна.

12¹.5. Холбоо нь дараах үндсэн эрх, үүрэгтэй:

12¹.5.1. гишүүдийн үйл ажиллагааны уялдаа, холбоог хангах;

12¹.5.2. гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах;

12¹.5.3. шүүхийн өмнө гишүүдийн эрх ашгийг хамгаалах;

12¹.5.4. даатгалын тохиолдлыг бууруулах, албан журмын даатгалын сургалт, сурталчилгаа явуулах.

12¹.6. Холбооны хөрөнгө дараах үндсэн эх үүсвэрээс бүрдэнэ:

12¹.6.1. үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн хөрөнгө;

12¹.6.2. элсэлтийн хураамж, гишүүний татвар болон бусад төлбөр;

12¹.6.3. эзэл, тусламж, хандив;

12¹.6.4. хуулиар зөвшөөрсөн бусад эх үүсвэр.

12¹.7. Санхүүгийн зохицуулах хороо нь Холбооны үйл ажиллагаатай холбогдсон дүрэм, журам, зааврыг баталж, уг холбооны үйл ажиллагаанд хяналт тавина.

12¹.8. Холбоо нь үйл ажиллагаагаа жил бүр Зохицуулах хороонд тайлагнах бөгөөд холбооны санхүүгийн хураангуй тайланг жил бүрийн эхний улиралд багтаан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

12¹.9. Холбоо нь хууль тогтоомжид нийцсэн, Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн дүрэмтэй байна.

2 дугаар зүйл. Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтын "даатгалын нөөц сан" гэсний дараа "албан журмын даатгалын



санд гэж, мөн зүйлийн 14.2.4 дэх заалтын "даатгалын нөөц санд" гэсний дараа "болон албан журмын даатгалын санд" гэж, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн "Даатгагч" гэсний дараа "болон энэ хуулийн 12¹ дүгээр зүйлд заасан Холбоо" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 83 дугаар зүйлийн 83.1.33 дахь заалтын "заавал" гэснийг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн "заавал даатгах" гэснийг "албан журмын" гэж, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн "Заавал даатгуулах" гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн "Заавал" гэснийг "албан журмын" гэж, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн "компанийн" гэснийг "компани болон Холбооны" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 8 дахь заалт:

"8/жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдах, автотээврийн хэрэгслийг ашиглах үедээ даатгалын баталгааг автотээврийн хэрэгсэлд байршуулах."

2/16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 8 дахь заалт:

"8/жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдаагүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх."

3/ 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6.Даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягт, уг



тодорхойлолтыг бүрдүүлэх зааврыг цагдаагийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуулийн 6¹ дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 6^{1.1.5} дахь заалт нэмсүгэй:

“6^{1.1.5}. тээврийн хэрэгслийн өмчлөгчийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах;”

2 дугаар зүйл. Автотээврийн тухай хуулийн 6¹ дүгээр зүйлийн 6^{1.1.5} дахь заалтын дугаарыг “6^{1.1.6}” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Автотээврийн тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 432 дугаар зүйлийн 432.1 дэх хэсгийн “заавал” гэснийг, 432 дугаар зүйлийн 432.2 дахь хэсгийн “заавал



даатгах" гэснийг "албан журмын" гэж, 444 дүгээр зүйлийн 444.5 дахь хэсгийн "заавал" гэснийг "албан журмаар" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮРИЙН ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үрийн тариалангийн даатгалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн "заавал" гэснийг "албан журмаар" гэж, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн "заавал" гэснийг "албан журмын" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.13 дахь заалтын "заавал" гэснийг "албан журмын" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2011 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 5 дахь хэсгийн "заавал" гэснийг "албан журмаар" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нотариатын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн "даатгалд заавал" гэснийг "албан журмын даатгалд" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

**ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Өмгөөллийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн "даатгалд" гэсний өмнө "албан журмын" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Жолоочийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 10 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

ЯЛТАН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан "Ялтан шилжүүлэх тухай гэрээ"-г Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 10 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар
хот

Жолоочийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Жолоочийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

1/Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий автотээвэр, төрийн захиргааны байгууллагын ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлэх, холбогдох сургалтад хамруулах, эдгээр байгууллагын бүтэц, орон тоог хянаж зохицуулах асуудлыг шийдвэрлэх;

2/Жолоочийн даатгалд хамруулах ажлыг жил бүрийн тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг явуулах, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах ажилтай нэгтгэн сум, дүүрэг бүрд зохион байгуулж байх;

3/Жолоочийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан мэдээллийн санд автотээвэр, цагдаа, татвар, гааль, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон даатгалын байгууллагад байгаа тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, техникийн хяналтын улсын үзлэг, тээврийн хэрэгслийн жолооч, зам тээврийн осол, зөрчлийн тухай мэдээллийг оруулах;



4/Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтыг аймаг, нийслэлд 2011 онд багтаан зохион байгуулах, сургалт, сурталчилгааны зориулалттай танилцуулга, гарын авлага, богино хэмжээний кино хийх, олон нийтийн радио, телевизийн сувгаар үнэ төлбөргүй сурталчлах,

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 10 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар
хот

**“Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах,
өөрчлөн байгуулах үндсэн чиглэл
батлах тухай” тогтоолын хавсралтад
нэмэлт оруулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Хурлаас **ТОГТООХ нь:**

1.“Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралтад дараах агуулгатай 5.11 дэх заалт нэмсүгэй:

“5.11.Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д заасан шинээр барих төмөр замын суурь бүтцийг барихад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийн тодорхой хэсгийг бүрдүүлэх зорилгоор “Монголын төмөр зам” ХК-ийн үнэлгээг олон улсын жишгийн дагуу шинэчлэн тогтоож, төрийн мэдлийн хувьцаа нь 51 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гаргаж, стратегийн болон санхүүгийн хөрөнгө оруулагч нарт санал болгох, хувьцааг Монголын хөрөнгийн бирж болон гадаадын нэр хүнд бүхий хөрөнгийн биржээр нээлттэй арилжина.”

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 8 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 264

Улаанбаатар
хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 347 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртэх журам"-д дор дурдсан агуулга бүхий Долоо, Наймдугаар бүлэг нэмсүгэй.

"Долоо. Орон сууц худалдаж авсны төлбөр төлөх, тооцоо хийх, баталгаажуулах

7.1. "100000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд баригдаж байгаа орон сууцнаас сонголт хийж, Орон сууцны тухай хуулийн 3.1.2-т заасан дэд бүтэц бүхий орон сууц захиалж гэрээ байгуулсан, зээлээр болон бэлэн мөнгөөр худалдан авсан иргэн Хүний хөгжил сангаас орон сууц худалдаж авсны төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэж болно.

7.2. Иргэн энэ журмын 7.1-д заасан хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд гаргана.

7.3. Хүсэлтэд иргэний овог, нэр, регистрийн дугаар, захиалсан, зээлээр болон бэлэн мөнгөөр худалдаж авсан орон сууцны төрөл, хэмжээ, байршил, орон сууцыг барихаар захиалга авсан болон барьсан байгууллагын нэр, дансны дугаар зэргийг тодорхой заасан байна. Тухайн иргэний орон сууцны төлбөрт гэр бүлийн бусад гишүүн хишиг, хувь оруулах хүсэлтэй бол түүний хүсэлтэд уг гэр бүлийн 16 нас хүрсэн гишүүн бүр гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Гэр бүлийн 16 нас хүрээгүй гишүүний орон сууцны төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлтийг эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч) нь төлөөлөн гаргана. Гэр бүлийн тухай хуулийн 63.1.4, 64.1.4, 64.1.5-д заасан хүний орон сууцны төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлтийг асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь төлөөлөн гаргана. Хүсэлтэд орон сууц захиалан бариулах болон худалдах, худалдан авах гэрээ, зээлийн гэрээний нотариатаар



баталгаажуулсан хуулбар, орон сууц худалдан авсан төлбөрийн баримт, зээл авсан банкны тодорхойлолт, тухайн гэр бүлийн гишүүдийн иргэний үнэмлэх, төрөний гэрчилгээний хуулбарыг хавсаргана.

7.4. Сум, хорооны нийгмийн ажилтан нь орон сууцны төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлт гаргасан иргэний хүсэлтийг хүлээн аваад тухайн иргэн бэлэн мөнгө хэлбэрээр хүртэх хишиг, хувиас гадна бусад хэлбэрээр хишиг, хувиа авсан эсэхийг нэгбүрчлэн нягтлан шалгана. Хишиг, хувиа орон сууц худалдан авсны төлбөр хэлбэрээр авах эрх бүхий иргэний нэр, хаяг, захиалсан болон худалдаж авсан орон сууцны төрөл, хэмжээ, байршил, төлбөрийн хэмжээ, орон сууцыг барихаар захиалга авсан байгууллага, иргэний нэр, дансны дугаар зэргийг багтаасан жагсаалтыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан маягт (цаашид "холбогдох маягт" гэх)-ын дагуу гаргаж аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлнэ.

7.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь орон сууцны төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх иргэний хүсэлтийг холбогдох маягтын дагуу нэгтгэж, аймаг, дүүргийн Засаг даргын гарын үсэг бүхий албан бичгээр болон цахим хэлбэрээр нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад сар бүр хүргүүлнэ.

7.6. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь орон сууцны төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх иргэний нэрсийн жагсаалтыг холбогдох маягтын дагуу улсын хэмжээнд нэгтгэн, аймаг, дүүрэг тус бүрээр шаардагдах хөрөнгийг тооцож, Орон сууцны санхүүжилтийн корпорацид сар бүр цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

7.7. Орон сууцны санхүүжилтийн корпораци орон сууцны төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлт гаргасан иргэний орон сууц нь "100000 орон сууц" хөтөлбөрт хамрагдаж байгаа эсэх, барилгын гүйцэтгэл нь 30-аас дээш хувьд хүрсэн эсэхийг хянан үзэж, орон сууц захиалагчдын мэдээллийн санд оруулж, уг санд орсон иргэдийн нэрсийн жагсаалтыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

7.8. Орон сууцны санхүүжилтийн корпораци нь орон сууцны төлбөр хэлбэрээр хишиг, хувийг олгоход шаардагдах хөрөнгийг захиалга авсан байгууллага, иргэн, зээл олгосон банк, төлбөрөө бүрэн төлж орон



сууцаа авсан иргэн тус бүрээр гаргаж, төлбөрийн дансны бүртгэлийг нэгтгэн, Сангийн яамны Төрийн сангийн газарт цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

7.9. Сангийн яамны Төрийн сангийн газар нь батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт багтаан захиалга авсан байгууллага, иргэн болон зээл олгосон банкинд Хүний хөгжил сангаас олгох хөрөнгийг орон сууцны захиалга авсан байгууллага, иргэн, зээл олгосон банк тус бүрийн дансанд шилжүүлнэ.

7.10. Сангийн яамны Төрийн сангийн газар нь төлбөрөө бүрэн төлж орон сууцаа худалдан авсан иргэнд олгох хөрөнгийг Хүний хөгжил сангийн сар, улирлын хуваарийн дагуу аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хүртээх санхүүжилтийн дансанд шилжүүлнэ.

7.11. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь төлбөрөө бүрэн төлж орон сууц худалдаж авсан иргэнд төлбөрийн баримт, орон сууц өмчлөх гэрчилгээг үндэслэн хишиг, хувийг нь банкаар дамжуулан олгоно.

7.12. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 7.7-д заасан жагсаалтыг аймаг, дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээр дамжуулан сум, хорооны нийгмийн ажилтанд хүргүүлнэ.

7.13. Сум, хорооны нийгмийн ажилтан нь энэ журмын 7.12-г заасан жагсаалтыг үндэслэн, уг иргэний хувийн хэрэгт тэмдэглэн, "Хүний хөгжил сан" дэвтэрт бичилт хийнэ.

Найм. Эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр
төлөх, тооцоо хийх, баталгаажуулах

8.1. Дараахь тохиолдолд иргэн эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэж болно:

8.1.1. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.1-д заасан тусламж үйлчилгээний зардал уг хуулийн 12.11-д заасан хэмжээнээс хэтэрч, төлбөрийг иргэн өөрөө хариуцан төлсөн;



8.1.2. Эрүүл мэндийн сайдын баталсан жагсаалтад орсон өндөр өртөг бүхий оношилгоо, эмчилгээ (MRI, компьютер томограф, ангиограф г.м), мэс засал (зүрх, тархи, нугас, гэмтлийн нөхөн сэргээх болон орлуулах, эрхтэн шилжүүлэх г.м)-ыг эх орондоо хийлгүүлсэн иргэн төлбөрөө өөрөө төлсөн;

8.2. Иргэн эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлтээ сум, хорооны нийгмийн ажилтанд гаргана.

8.3. Хүсэлтэд иргэний овог, нэр, регистрийн дугаар, хаяг, үйлчилгээ авсан эмнэлгийн байгууллагын нэр, байршил, харилцах дансны дугаар зэргийг тодорхой заасан байна. Хүсэлтэд эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийн баримт (төлбөр төлсөн баримт, эсхүл нэхэмжлэл зэрэг)-ыг хавсаргана. Тухайн иргэний эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрт гэр бүлийн бусад гишүүд хишиг, хувиа оруулах хүсэлтэй бол түүний хүсэлтэд уг гэр бүлийн 16 нас хүрсэн гишүүн бүр гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Гэр бүлийн 16 нас хүрээгүй гишүүний эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлтийг эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч) нь төлөөлөн гаргана.

8.4. Сум, хорооны нийгмийн ажилтан нь эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлт гаргасан иргэний нэр, хаяг, үйлчилгээ авсан байгууллагын нэр, байршил, төлбөрийн хэмжээ, харилцах дансны дугаар зэргийг багтаасан жагсаалтыг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан маягтын дагуу гаргаж аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хүргүүлнэ.

8.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн хэлтэс нь эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх иргэний хүсэлтийг аймаг, дүүргийн хэмжээнд нэгтгэж, холбогдох эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан байгууллагын мэдээллийн сантай тулган шалгаж, нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

8.6. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх иргэний жагсаалтыг улсын хэмжээнд нэгтгэж шаардагдах хөрөнгийг батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дүнд багтаан аймаг, дүүрэг тус бүрээр гаргаж, Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлнэ.



8.7. Сангийн яамны Төрийн сангийн газар нь Хүний хөгжил сангаас энэхүү журмын 8.6-д заасан хөрөнгийг аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хүртээх санхүүжилтийн дансанд шилжүүлнэ.

8.8. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс нь эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэх хүсэлт гаргасан иргэдийн нэрсийн жагсаалтыг үндэслэн хүсэлт гаргасан он, сар, өдрийн эрэмбээр холбогдох эрүүл мэндийн байгууллага, иргэний дансанд төлбөрийг шилжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтаа сум, хорооны нийгмийн ажилтанд хүргүүлнэ.

8.9. Сум, хорооны нийгмийн ажилтан нь энэ журмын 8.8-д заасан жагсаалтыг үндэслэн, уг иргэний хувийн хэрэгт тэмдэглэн, "Хүний хөгжил сан" дэвтэрт бичилт хийнэ."

2. "Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртэх журам"-ын Тав, Есдүгээр бүлэгт дор дурдсан агуулгатай 5.1', 9.1.3 дахь заалт тус тус нэмсүгэй:

"5.1'. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежийн өдрийн болон орой, эчнээ ангид дипломын, бакалаврын, магистрын, докторын шатлалд 2011-2012 оны хичээлийн жилд суралцаж байгаа иргэн Хүний хөгжил сангаас 2012 онд бэлэн мөнгө хэлбэрээр хүртэх хишиг, хувиас гадна сургалтын төлбөр хэлбэрээр хишиг, хувь хүртэж болно."

"9.1.3. Орон сууц худалдан авсны, эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ нэг иргэнд 1000000 (нэг сая) хүртэл төгрөг байна."

3. Мөн журмын 5.5-д "2010-2011 он" гэсний дараа "2011-2012 он" гэж, 7.1.2-ын "500000 (таван зуун мянган) төгрөг" гэсний дараа "2011-2012 оны хичээлийн жилд 491960 (дөрвөн зуун ерэн нэгэн мянга есөн зуун жаран) төгрөг," гэж тус тус нэмсүгэй.

4. "Монгол Улсын иргэн хишиг, хувь хүртэх журам"-ын 10.3-т "10.2" гэснийг "12.2" гэж, мөн журмын "Долоодугаар бүлгийн нэрийг "Сургалтын, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн, орон сууц худалдан авсны, эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ" гэж өөрчлөн найруулж, тус бүлгийн болон Найм, Ес, Аравдугаар бүлгийн дугаарыг "Ес", "Арав" "Арван нэг" "Арван хоёр" гэж, мөн бүлгүүдийн доторхи хэсэг, заалтын дугаарыг бүлгийн шинэ дугаарт нийцүүлэн тус тус өөрчилсүгэй.



5. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Хүний хөгжил сангийн 2011 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хуульд тусгах замаар шийдвэрлэхийг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

Т.ГАНДИ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 9 дүгээр
сарын 7-ны өдөр

Дугаар 271

Улаанбаатар
хот

Түүх, соёлын дурсгалд хамааруулж, хамгаалалтын бүс тогтоох тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.3,17.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 175 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-ын "4.Булган аймгийн улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал" гэсэн хэсэгт "11.Баяннуур сумын Майхан уулын энгэрт орших эртний нүүдэлчөий язгууртны бунхант булш" гэж нэмсүгэй.

2. Түүх, соёлын үл хөдлөх дурсгал болох Булган аймгийн Баяннуур сумын Майхан уулын энгэрт орших эртний нүүдэлчөний язгууртны бунхант булшны хамгаалалтын бүсийг 700 га газар байхаар тогтоож, хамгаалалтын бүсийн хилийн цэгүүдийн геодезийн солбицлыг хавсралт ёсоор баталсугай.



3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан хамгаалалтын бүсэд барилга байгууламж шавхээр барих, хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулахыг хориглож, бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шон тэмдэг тавих, хашаа барих зэрэг хамгаалалтын дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Булган аймгийн Засаг дарга М.Оюунбатад даалгасугай.

4. Эртний нүүдэлчний язгууртны бунхант булш, ховор олдворуудыг хамгаалах, сэргээн засварлах, орчны тохижилт хийхэд шаардагдах 80.0 (наян) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Е.ОТГОНБАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2011 оны 271 дүгээр
тогтоолын хавсралт

ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ХИЛИЙН ЦЭГҮҮД

(Солбицлын жагсаалт)

Цэгийн дугаар	Байршил	Геодезийн солбицол	
		X	Y
1	Булган аймгийн Баяннуур сумын Майхан уулын энгэрт орших эртний нүүдэлчний язгууртны бунхант булш	47.57.05	104.29.57
2		47.54.10	104.30.55
3		47.56.47	104.33.25
4		47.57.29	104.32.10
5		47.55.39	104.32.57

Хаяг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2

Индекс: 14003



Үлкен Іле Жүзінде Талаптың тазарып кешікпесіне келген,
Үлес 329487